

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”**

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234735

**ЭРТНИЙ БИЧЭЭС НЬ ХЭЛНИЙ ТҮҮХИЙГ СУДЛАХ
ЧУХАЛ ЭХ СУРВАЛЖ МӨН**

Л.Маналжав

Булган аймгийн Могод сумын нутгаас олдсон Хүйс Толгойн (ХТБ) бичээсийг монгол хэлээр, брахми бичгээр тэмдэглэсэн тухай болон уг бичээстэй хөшөөг монгол хэлбичгийн түүхэн баримт, хосгүй үнэт дурсгалын хувьд Төрийн ордонд залсан зэрэг нь Монголчуудын хувьд 2019 оны тэмдэглэлт үйл явдлын нэг байлаа. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслээр, ялангуяа бичээсийг судалсан эрдэмтдийн талаар өргөн мэдээлэв^{1,2}.

Эдгээр мэдээллийн дотор брахми бичгийн дурсгалыг уншиж судлахад онолын гүнзгий мэдлэг нэн чухлыг цохон тэмдэглэснээс гадна, брахми бичиг монголд хэзээ, хаагуур нэвтэрсэн түүхэн нөхцөл байдлыг тогтоохын чухлыг дурдсан нь маш зүйтэй санагдлаа. Эртний бичээс нь тэрхүү бичээсийн хэлний түүхийг судлах хэрэглэгдэхүүн, эх сурвалж нь болдог учраас бичгийг тайлан унших, улмаар ямар хэлээр бичиж тэмдэглэснийг тогтоохын тулд орчин цагийн судалгааны янз бүрийн аргуудыг хэрэглэн нарийвчлан судлах шаардлага аяндаа гарч ирдэг. Уг бичээсийг хэлний талаас судалсан байдлыг Монголын хэл шинжлэлчид анхааралдаа авсан байна. Тухайлбал, А. Вовин, Д. Мауэ нарын судалгаатай танилцсан³.

Монгол нутгаас олдож байгаа олон хэл, олон төрлийн бичгээр тэмдэглэсэн эртний бичээсүүд нь Төв болон дундад Азийн түүхийг судлах чухал эх сурвалж болж ирсэн. Эдгээр бичээсүүдийг түүх, археологи, хэл бичгийн болон хэл шинжлэлийн талаас судалдаг. Зөвхөн нэг жишээ дурдахад руни бичгээр тэмдэглэсэн бичээсүүдэд дурдсан үйл явдлуудыг харьцуулан судлах ажлыг 1894-1896 оны үед В.В. Радлов, В. Томсен, Э. Паркер нарын хийсэн судалгаанаас анхны үр дүн гарч эхэлсэн бол, 1930-1940 оны үед Орхон-Енисейн бичгийн судалгааны шинэ үе эхэлсэн нь Түрэг хэл бичгийн судалгаатай холбоотой. Энэ нь эртний Уйгурын эх бичиг, Махмуд Кашкарын толь бичиг зэрэг сурвалжуудыг судалгааны эргэлтэнд оруулсантай холбоотой. Ийнхүү түрэг хэлүүдийг сонирхон судалж, бусад хэлтэй зэрэгцүүлсэн судалж эхэлсэн. Ийм нөхцөл байдалд эртний түрэг хэлний дурсгалуудыг судалж, улмаар алтай хэл шинжлэлийн ач холбогдол өссөн юм. Хэл шинжлэлийн ухааны хүрээнд залгамал хэлүүдийн дотроос түрэг хэлийг хамгийн сайн судлагдсан хэмээн үздэг. Монгол хэлийг, ялангуяа монгол хэлний цуваа болон хам цагийн судалгааг ажиглахад, монгол хэл ч мөн түрэг хэлнээс дутуугүй судлагдсан гэж үзэж болмоор. Энэ нь нэг талаас монгол хэл нь

бичгийн болон аман зохиолын арвин их өвтэй, нөгөө талаас гадаад, дотоодын эрдэмтэд монгол хэлийг судалж ирсэн уламжлалтай.

Шинээр олдсон Хүйс Толгойн Бичээсийн (ХТБ) судалгаа нь монгол хэлний түүхийг судлах бас нэг чухал эх сурвалж бий болж байна гэсэн үг. Бичээсийг тайлан унших оролдлого хийж, хэл шинжлэлийн үүднээс судалсан хэд хэдэн эрдэмтэд байгаагийн дотор нэлээд нарийн судалсан нь Германы эрдэмтэн Дитер Мауэ, Францын Александр Вовин нар юм. Эдгээр эрдэмтэд 2014 оноос ажлаа эхэлж, судалгааныхаа үр дүнг дэс дараатайгаар хэвлэн нийтлүүлж, эрдмийн хамт олонд танилцуулсан байна. Үүнд: Дитер Мауэ 2017 онд “Хүйс Толгойн бичээс – тэмдэг болон авиа” (The Khüis Tolgoi inscription – signs and sounds) мөн 2017 онд Дитер Мауэ, Мехмет Өлмез хоёр Этьен Васаиере, Александр Вовиний хамт 2017 оны Алтай судлалын Олон улсын бага хурал дээр “Монголын тал нутгаас олдсон эртний бичээсүүд” сэдэвт хэлэлцүүлгийн хүрээнд дээр дурдсан эрдэмтэд тус тусдаа сонсгол хийжээ. Үүнд: Д. Мауэ “Тал нутгийн брахми: тайлан унших ба түүний онцлог” (The steppe brahmi – decipherment and peculiarities), А. Вовин: “Хүйс Толгойн бичээсийн хэл” (The language of the Khüis Tolgoi inscription), Э.де Вайере, “Нири Хаан ба Хүйс Толгойн бичээсийн түүхэн орчин” (Niri Kagan and the historical background of Khüis Tolgoi inscription). Эдгээр илтгэлүүдийг бүрэн эхээр нь 2018 оны ‘Journal Asiatique 306’-д хэвлүүлсэн байна. Эдгээр эрдэмтдийн дотроос энэхүү бичээсийн хэлийг нарийвчлан судалсан нь А. Вовин юм. Авьяаслаг судлаач, хэл шинжлэлч А. Вовин хэрэв амьд сэрүүн байсан бол улам их нээлт хийх байсан гэдэгт эргэлзэхгүй байна.

А. Вовин 2017 оны 8-р сарын 31-нд Унгарын Секешфехерварт болсон Алтай судлалын 60-р бага хуралд “Хүйс Толгойн бичээсийн тайлбар” (Interpretation of Khüis Tolgoi inscription) тавьсан байна. Улмаар А. Вовин 2019 онд “Евразийн хэл шинжлэл 1” (International Journal of Eurasian linguistics 1) “Эртний Монгол хэлний тойм: Бугатын брахми бичиг ба Khüis Tolgoi бичээс” гарчигтай бүрэн хэмжээний судалгааны өгүүллийг хэвлүүлсэн байна.

Энэхүү бичээсийг нээн олсны ач холбогдлыг А. Вовин гурван зүйлээр авч үзсэнтэй санал нэг байна. Энэ нь нэгдүгээрт, монгол хэлний хамгийн эртний баримт гэж үзэж байсан (Чингисийн чулууны бичээс 1224-1225 он) хугацааг даруй 600 жилээр урагшлуулсан. Хоёрдугаарт, энэхүү бичээсийн хэл нь дундад үеийн монгол хэлтэй нэлээд ойр боловч, энд эртний монгол хэлэнд байсан болов уу хэмээн сэргээж байсан хэлбэрүүдийг тоймлосон. Эцэст нь дундад зууны үеийн Төв Ази дахь угсаатны хэл шинжлэлийн түүхийн тухай ерөнхий ойлголтонд ихээхэн өөрчлөлт орно гэж үзжээ. Энэхүү бичээс нь Төв Азийн тал нутгаас олдсон алтай язгуурын анхны хэл нь эртний түрэг бус, монгол байжээ гэдэг дүгнэлтэнд хүргэж байна.

Хүйс Толгойн бичээсийг Бугатын бичээстэй харьцуулж үзсэнээс гадна Зүүн Казакстаны Керегентасаас олдсон богино хэмжээний брахми бичиг нь мөн Хүйс Толгойн бичээстэй адил зэрэг нь тэр үед ямар овог аймаг, ямар хэл гол байр суурийг эзэлж байсан зэрэг асуултанд хариу өгөх ёстой.

Дээр дурдсан эрдэмтэд, ялангуяа бичээсийн хэл судлаачид (А. Вовин, Д. Мауэ) Хүйс Толгойн бичээсийн хэлний бүтэц бүрэлдэхүүний хэсгүүдийн давтамжийг дундад үеийн монгол хэлний бүтэцтэй зэрэгцүүлэн судалж харьцуулж үзжээ.

Хэлний зарим үзэгдэл нь түгээмэл хэл шинжлэлд ч хамаатай. Агуулга нь Түрэгийн эзэнт улстай хамаатай энэхүү бичээс нь монгол хэлээр брахми бичгээр тэмдэглэсэн нь улам ч сонирхолтой. Энэ нь Монголчуудын бичиг үсгийн түүхийг 1400 жилээр урагшлуулж байна. Тал нутгаас олдсон алтай хэв шинжийн хэл нь эртний Түрэг бус, монгол байсныг нотолж байна.

Хүйс Толгойн бичээсийг тайлан унших нь монгол хэлний түүхээр хязгаарлагдахгүй, Алтай судлалд ч хамаарагдах ач холбогдолтой юм. Монголд Алтай судлалын хамтлаг (Л. Болд тэргүүтэй) олон талын үйл ажиллагаа явуулдаг. Аль 1930 онд Ж.В.Страленберг түрэг, монгол, тунгус-манж хэлүүдийг алтай хэлний бүлэгт оруулахыг санал болгосноос хойш Алтай судлалтай хамт яригддаг нэг чиглэл бол Урал-Алтай судлал болсон. Энэ нь анх М. А. Кастрен Алтай болон Сибирийг финно-уйгур ард түмний өвөг эх орон болох тухай санааг дэвшүүлсэнтэй холбоотой бөгөөд ийнхүү Финландын олон эрдэмтэд өөрийн соёлын ул мөрийг дээр дурдсан газар нутгаас эрж хайх болсонтой холбоотой. Мөн энэхүү таамаглалтай холбогдон тэр үед Сибирээс олдож байсан үл мэдэгдэх бичээсүүдийг тайлан унших, судлах үйл ажиллагаа идэвхжсэн байна. 1883 онд Хедьсинкид “Финно-Уйгурын нийгэмлэг” байгуулагдсан бөгөөд ийнхүү алтай судлал нь Урал-Алтай судлал гэсэн бас нэг чиглэлтэй болов. Энэ бүхэн нь аливаа үндэстэн өөрийн угсаа гарал, өв уламжлал, түүхэн хэлхээ холбоог эрэлхийлэн судалж байдгийн жишээ юм. Ийм төрлийн судалгаанд бичгийн эх сурвалжууд, түүний дотор эрт цагийн хад чулууны бичээсүүд чухал ач холбогдолтой.

VI – XIII зуун бол янз бүрийн овог аймгуудын хэл аялгуу зэрэгцэн оршиж, харилцан нөлөөлж, оршин тогтнож байсан үе. Зөвхөн “Монголын Нууц Товчоо”-нд дурдсанаар “есөн хэлтэн” гэсэн нь янз бүрийн хэл аялгууг хэлсэн бололтой. Гэтэл “МНТ”-нд овог аймгийн хүмүүс хоорондоо ойлголцохгүй, хэлмэрчилж байсан тухай зүйл үгүй. Харин тэдгээр олон овог аймгийн хүмүүс нь монгол, түрэг угсааны байж таарна. Үүнээс үүдээд монгол хэлний үгсийн сангийн бүрэлдэхүүнд байгаа түрэг (уйгур) хэлний хүчин зүйл нь урт удаан хугацааны туршид хоёр хэлийг хамт хэрэглэж байсны үр дүнд л ийм гүнзгийгээр харилцан нөлөөлнө гэж судлаачид үзэж байна. В. И. Котвич монгол хэлний үгсийн сангийн 25%, үг зүйн 50%-д түрэг хэлтэй нийтлэг махбод байгааг тогтоосныг санах хэрэгтэй гээд ийм үзэгдэл нь зөвхөн нэг хэлнээс нөгөөд зээлдсэн гэхэд хэтэрхий их хэмжээтэй байгааг цохон тэмдэглэжээ⁴. Улмаар П. Б. Коновалов дундад зууны үед монгол, түрэгүүд аль алиныхаа хэлийг мэддэг байсан гээд, эсвэл нэгэн нэгдмэл хэл байснаа, түрэг болон монгол хэл болон хуваагдсан гэжээ. Энэ нь бид эртний бичээсүүдийн хэлийг, ялангуяа төрөл бүтэцтэй хэлийг харьцуулан судлах нь чухал гэдгийг харуулж байна.

А. Вовин олон улсын Евразийн хэл шинжлэл сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлдээ ХТБ Бугатын бичээсүүдийн жишээн дээр болон бичээсийн хэлний авиалбар зүй, үг зүй, өгүүлбэр зүйн талаас задлан шинжилж тайлбарлахдаа дундад үеийн монгол хэлтэй харьцуулан үзсэн байна. Жишээлбэл, ХТБ-д өвөг монгол хэлний үгийн эхний р- хадгалагдан үлдсэн байна. Дундад үеийн монгол хэлний үгийн эхний h – нь р – гаас үүссэн гэж үздэг. Жишээлбэл, ра{ran} – ард түмэн, хүн (Бу. Б), дундад үеийн монгол хэлэнд haran, мөн түүнчлэн дундад үеийн hūker (Бу. Б) брахми бичээст rüker (үхэр) rüneken (Бу. Б) нь дундад үеийн монгол хэлний

hünegen гэх мэт. Гэтэл энэхүү үзэгдлийг түгээмэл хэл шинжлэлийн үүднээс ч авч үзэж болмоор. Тухайлбал, /p/ авиа нь сулран үгүй болох хандлагатай учраас дэлхийн олон хэлэнд үгүй болсон байна⁵. Тухайлбал, p>f>h>Ø. Мөн түүнчлэн төрөл бус хэлний үзэгдлийг ч харьцуулан судлах оролдлого хийж байна. Жишээлбэл, Энэтхэг-Европын хэлний аймагт багтах, мөхсөн хэл болох тохар А. В хоёр төрлийн хэлүүд нэгэн цагт алтай язгуурын хэлтэй уулзан золгож байсан бөгөөд тохар болон алтай хэлний үгийн санд адил төстэй болон ялгаатай зүйлүүд байдаг тухай хэл шинжлэлчид өгүүлдэг. Зарим хэл шинжлэлчид монгол хэлний үгийн эхний h-, манж хэлний f-тэй тохар хэлний k-тай тохирно гэжээ^{6,7}. Жишээлбэл:

Хэл	галиг	Үгийн утга
Тохар А	com	өдөр, нар
Тохар В	kaun	өдөр, нар
Эртний түрэг	kün/gün	нар, өдөр
Дундад үеийн Монгол	hon	он
Дагуур	ho:n	он
Манж	fon	цаг, улирал
Хятан	po	цаг
Солонгос	rom	хавар

Хэлний түүхийн баримт болох эртний бичээсийг судлахад эх бичиг судлалын болон хэл шинжлэлийн цогц аргуудыг хэрэглэдэг бөгөөд судалгааны үр дүнд гарсан дүгнэлт, гаргалгаа нь эргээд хэлний хэв шинжийн судалгаа, зэрэгцүүлсэн хэл шинжлэл болон түгээмэл хэл шинжлэлд ч хувь нэмэр оруулах боломжтой юм.

Эшлэл:

- ¹ Д. Цэрэнсодном, Бярман бичиг Монголд орж ирсэн түүхэн үндэс, Эх хэл бичиг (сэтгүүл) 2022, No.3 (39) УБ
- ² Я. Сумъяа, Бярман үсгийн соёлыг зургаан зуунаар урагшлуулсан Хүйс Толгойн бичээс, Эх хэлбичиг (сэтгүүл) 2022, No.3 (39) х29
- ³ Монгол хэл судлал, Боть 1, х33-34
- ⁴ Рассадин В. И. О некоторых реликтовых явлениях тюрко –монгольских языковых союзов (V международный конгресс Монголовезов, УБ, сентябрь 1987)
- ⁵ Котвич В. Л. Исследования по алтайским языкам, М, 1962
- ⁶ Maddieson, I. Patterns of sounds, Cambridge: Cambridge University Press
- ⁷ Penglin Wan, On the origin of the Middle Mongolian initial h- and motivation for its loss, 33rd International Congress of Asian and North African Studies, Toronto, August 19-25, 1990

Ашигласан ном

- Солонгод Л. Хурцбаатар , 1400 жилийн өмнөх өвөг монгол хэл (Хүйс Толгойн бичээсийн судлал), Elias Verlag imoFiF e.v, 2020
- Монгол хэл судлалын түүх, монгол хэл аялгуу, үсэг бичиг, авиа судлал, Боть 1, Улаанбаатар 2020
- Dieter Maue and Mehmet Olmez, The Khüis Tolgoi inscription, Journal Asiatique 306, 2018
- Alexander Vovin, Interpretation of the Khüis Tolgoi inscription, Presented at 60th PIAC, Hungary 2017
- Dieter Maue, The Khüis Tolgoi inscription – signs and sounds, Schwarzenborn 2017
- Alexander Vovin, A sketch of the earliest Mongolic language: the brahmi Bugut and Khüis Tolgoi Inscription, International of Eurasian linguistics 1 (2019)
- Ricardo Mairal and Juana Gil, Linguistic Universals, Cambridge University Press, 2006
- Л. Болд, БНМАУ дахь хадны бичээс, УБ, 1990
- Л. Болд, Орхон бичгийн дурсгал, УБ, 2011
- С.Г. Кляшторный, История центральной Азии и памятники рунического письма